

ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ИНД-77-ИЙН ХАРЬЦУУЛАЛТ

<p align="center">Нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх байгууламж (Шинэчлэгдэж байгаа) / 23 хуудас/ 2014 оны NZ amend.4</p>	<p align="center">НАМ ӨНДРИЙН НИСЛЭГТ СААД УЧРУУЛАХ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГАА (Хүчинтэй мөрдөгдөж байгаа) / 15 хуудас (үндсэн дүрэм-62 хуудастай байсан)/1997 оны NZ original</p>	<p align="center">Тайлбар</p>
<p>77.1 Зорилго (а) Энэ зүйлийн (b)-г харгалзан, энэ Дүрэм нь Монгол Улсын зэвсэгт хүчний харъяалах бүсийг оролцуулан, Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа хийхийг санал болгож байгаа этгээдэд тавих шаардлагыг тогтооно: <u>(1) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох байгууламж барих, эсхүл өөрчлөх; эсхүл</u> <u>(2) нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэж болох байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах.</u> (b) Энэ Дүрэм нь дараах агаарын хөлөг болон үйл ажиллагаанд хамаарахгүй: <u>(1) Монгол Улсын зэвсэгт хүчний анги салбар, эсхүл дараах үйл ажиллагаатай холбоотой үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын зэвсэгт хүчний агаарын хөлөг:</u> <u>(i) дайны, эсхүл бусад онцгой нөхцөл; эсхүл</u> <u>(ii) Монгол Улс болон Монгол Улсын бусад ашиг сонирхол; эсхүл</u> <u>(iii) онцгой нөхцөлийн үед ард иргэдэд түслэмж үзүүлэх; эсхүл</u> <u>(iv) нийтэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх; эсхүл</u> <u>(v) ИНД-71-ийн дагуу цэргийн зорилгоор тогтоосон хязгаарлалттай, аюултай, эсхүл цэргийн үйл ажиллагааны бүсэд гүйцэтгэсэн ажиллагаа;</u> <u>(2) ИНД-101-д хамаарах үйл ажиллагаа.</u></p>	<p>77.1. Зорилго (а) Энэ дүрмийн зорилго нь нам өндрийн нислэгт саад учруулж болзошгүй барилга байгууламж шинээр барих, өргөтгөх болон үйл ажиллагаа явуулах журмыг тогтооход оршино.</p>	<p align="center">-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>77.3 Нэр томьёо ба товчлол Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.</p>	<p>77.3. Тодорхойлолт</p>	<p align="center">-Нэр томьёоны тайлбар ИНД-1-д орсон.</p>
<p>77.5 Байгууламж барих, эсхүл өөрчлөх мэдэгдэл <u>Байгууламж барих, эсхүл өөрчлөхийг</u> санал болгож байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу саналыг <u>Даргад</u> мэдэгдэх үүрэгтэй, хэрэв санал болгосон байгууламж, эсхүл түүний өөрчлөлт нь: (1) тухайн байрлалын газрын түвшнээс дээш (AGL) 60 м-ээс <u>дээш өргөгдөх</u> бол; эсхүл (2) <u>тухайн бүсийн модны нийтлэг өндрөөс 18 м-ээр илүү гарсан ба нам өндрийн агаараас гүйцэтгэх ажиллагааны бүсэд, эсхүл бусад нам өндрийн нислэгийн бүсэд, эсхүл ИНД-71-ийн дагуу</u></p>	<p>77.5. Барилга барих, өргөтгөх, өөрчлөх тухай мэдэгдэх. (а) <u>Нам өндрийн нислэгийн бүсэд барилга барих, өргөтгөх,</u> өөрчлөх ажил хийх гэж буй этгээд нь дараах тохиолдлуудад энэ дүрмийн 77.13-ын дагуу <u>ИНЕГ-ын даргад</u> мэдэгдэнэ: 1/ барилгын өндөр нь тухайн талбайн газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метрээс <u>илүү гарах</u> бол; 2/ <u>барилга нь ИНД-73 -д заасан бүсэд баригдах бол;</u></p>	<p align="center">-Орчуулга найруулга засагдсан</p> <p align="center">-Amend.1-ээр нэмэлт өөрчлөлт орсон</p>

[ТОГТООСОН НАМ ӨНДРИЙН НИСЛЭГИЙН ЗООНД, ЭСХҮЛ НАМ ТҮВШНИЙ НИСЛЭГИЙН ЗАМД БАЙРЛАДАГ БОЛ; ЭСХҮЛ](#)

(3) Хавсралт А-ийн А.1 болон А.2 зурагт дүрсэлсэн аэродромын ойртолтын, эсхүл хөөрөлтийн гадаргуугаас доош байрладаг ба Хавсралт А-д дүрсэлсэн дараах аль нэг нөхцөлөөс гадагш болон [дээш өргөгдсөн гадаргуугаас дээш өндөрт үргэлжлэх](#) бол:

(i) МСТOW нь 5700 кг-аас дээш жинтэй агаарын хөлөг ашигладаг, [эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа](#) бол налуу нь ХБЗ-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс 1:83;

(ii) МСТOW нь 5700 кг, эсхүл түүнээс доош жинтэй агаарын хөлөг ашигладаг, [эсхүл ашиглахаар төлөвлөж байгаа](#) бол, налуу нь ХБЗ-ын хөөрөлтийн гадаргуугийн эхлэл цэгээс 1:50;

(iii) налуу нь хэлипортын аюулгүй байдлын бүсийн хамгийн ойрын цэгээс 1:25; эсхүл

(4) дараах [аэродромын конус, дотор талын хэвтээ, эсхүл шилжилтийн хажуу](#) гадаргууг огтолсон бол:

(i) Хавсралт А-ийн А.1-д дүрсэлсэн; эсхүл

(ii) ИИД-139-д заасан; эсхүл

(iii) [тухайн орон нутгийн газрын зурагт тогтоосон.](#)

3/ барилга нь [ИИД-139-д заасан](#) ойртолтын ба хөөрөлтийн агаарын замын доорх газрын гадаргуу дээр байрлах бөгөөд Хавсралт А-д үзүүлсэн байдлаар тухайн саадын хязгаарлагдах гадаргуугаас дээш гарсан, мөн дараах байдалтайгаар гадагшаа буюу дээш [сунаж байрлах](#) бол:

3.1 5700 кг-аас дээш хөөрөлтийн жинтэй агаарын хөлөгт ашиглах ХБЗ-аас хөөрөх чиглэлд харааны баримжаагаар 1:83 налуу гадаргуу;

3.2 5700 кг-тай тэнцүү буюу бага хөөрөлтийн жинтэй агаарын хөлөгт ашиглах ХБЗ-аас хөөрөлтийн чиглэлд харааны баримжаагаар 1:50 налуу гадаргуу;

3.3 нисдэг тэрэгний аюулгүйн талбайн хамгийн ойр цэгээс 1:25 налуу гадаргуу.

4/ барилга, байгууламжийн өндөр нь Хавсралт А-д үзүүлсэн гадаргуунуудаас (эдгээр гадаргуунуудын хэмжээг ИИД-139-ийн Зөвлөмжийн цуврал ЗЦ139-06-д зааж өгсөн байна) илүү гарахаар бол.

77.7 [Агаарын үрсгал \(efflux\)](#), гэрэл, эсхүл лазер үүсгэх байгууламж ашиглах мэдэгдэл

(a) Тухайн байгууламжийг ашиглахаар санал болгож байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу саналыг [Даргад](#) мэдэгдэх үүрэгтэй, хэрэв:

(1) тухайн байгууламж нь аэродромын саадыг хязгаарлах [бүсийг огтлон](#) 4.3 м/с-ээс дээш хурдтай [агаарын үрсгал үүсгэх](#) бол; эсхүл

(2) тухайн байгууламж нь AGL 60 м-ээс дээш өндөрт 4.3 м/с-ээс дээш хурдтай [агаарын үрсгал](#) үүсгэх бол.

(b) Гэрэл, эсхүл лазерыг ашиглахаар санал болгож байгаа этгээд нь дараах тохиолдолд 77.13-ын дагуу [Даргад](#) мэдэгдэх үүрэгтэй, хэрэв:

(1) гэрэл, эсхүл лазер нь нисгэгчийн [харааг гялбуулах](#), эсхүл бусдаар нөлөөлснөөр агаарын хөлөгт аюул учруулах бол; эсхүл

(2) лазерын хувьд, тусгал нь нислэг үйлдэх агаарын зайд хэрэглэгдэх [S/AS 2211 стандартад](#) заасан зөвшөөрөгдөх максимум хэмжээнээс их бол; эсхүл

(3) [дараах алдаанаас үүдэн агаарын хөлөгт аюул учруулах бол:](#)

(i) [аэродромд, эсхүл түүний ойролцоо байрлуулсан, эсхүл](#)

77.7. Байгууламж, гэрэл буюу лазер ашиглах тухай мэдэгдэх

(a) Байгууламж барьж ашиглах гэж байгаа этгээд нь дараах тохиолдолд энэ дүрмийн 77.13-ын дагуу [ИНЕГ-ЫН](#) даргад мэдэгдэнэ:

1/ Байгууламж нь аэродромын саадын хязгаарлагдах [гадаргуугийн дагуу](#) 4.3 м/сек-ээс дээш [салхины нөөлгө, хүйлрэл үүсгэх](#) магадлалтай бол;

2/ Байгууламж нь газрын гадаргуугийн түвшнээс 60 метрээс дээш зайд 4.3 м/сек-ээс дээш салхины нөөлгө, [хүйлрэл үүсгэх](#) магадлалтай бол;

(б) Гэрэл, эсвэл лазерын [туяа](#) ашиглах гэж байгаа этгээд нь дараах тохиолдолд энэ дүрмийн 77.13 заалтын дагуу [ИНЕГ-ЫН](#) даргад мэдэгдэнэ:

1/ гэрэл буюу лазерын хурц тусгал нисгэгчийн болон нислэгийн удирдагчийн хараанд нөлөөлж агаарын хөлгийн нислэгт аюул [үчрүүлж болзошгүй бол;](#)

2/ лазерын туяа нь [Монгол Улсын стандартын](#) хамгийн их зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд нам өндрийн агаарын зайн нислэгт нөлөөлөхөөр бол.

-Орчуулга найруулга засагдсан

-Орхигдуулсан заалтыг нөхөж

<p>байрлуулахыг зөвшөөрсөн гэрэл, эсхүл гэрлийн системийн хэсэг; эсхүл (ii)нислэг үйлдэх агаарын зайн аюулыг тэмдэглэсэн гэрлэн тэмдэглэгээ.</p>		оруулсан
<p>77.9 Зэвсэг хэрэглэх мэдэгдэл Хэрэв тухайн этгээд, эсхүл байгууллагыг төлөөлсөн этгээд нь дараах өндрөөс дээш нисэх траектортой пуужин/сум хөөргөх, эсхүл буудах зэвсэг хэрэглэхээр санал болгож байгаа бол, 77.13-ын дагуу Даргад мэдээлэх үүрэгтэй: (1)хэрэв аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор бол, 45 м-ээс; эсхүл (2)хэрэв аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайтай бол, 120 м-ээс.</p>	<p>77.9. Галт зэвсэг ашиглах тухай мэдэгдэх (a) Газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метрээс дээш замыг туулах биетийг буудах, эсвэл пуужин хөөргөх шаардлагатай бол уг ажлыг зохион байгуулж байгаа этгээд нь энэ тухайгаа энэ дүрмийн 77.13 заалтын дагуу ИНЕГ-ын даргад мэдэгдэнэ.</p>	<p>-Amend.2-өөр нэмэлт өөрчлөлт орсон</p> <p>-Шаардлагыг нарийвчилж тусгасан.</p>
<p>77.11 Пиротехник ашиглах мэдэгдэл (a) Хэрэв аливаа этгээд нь дараах өндрөөс дээш нисэх траектортой пуужин/сум хөөргөх, эсхүл буудах ажиллагаа оролцсон пиротехникийн үзүүлбэр хийхээр санал болгож байгаа бол, 77.13-ын дагуу Даргад мэдэгдэх үүрэгтэй: (1)хэрэв аэродромын хил хязгаараас 4 км-ийн дотор бол, 45 м-ээс; эсхүл (2)хэрэв аэродромын хил хязгаараас 4 км-ээс хол зайтай бол, 120 м-ээс.</p>	<p>77.11. Тэсэрч дэлбэрэх зүйлийг ашиглах тухай мэдэгдэх (a) Тэсэрч дэлбэрэх зүйлийн тусгалыг ашиглах, эсвэл тэдгээрийг пуужингаар хөөргөх ажиллагаа нь газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метрээс дээш өндөрт явагдахаар бол уг ажлыг зохион байгуулж байгаа этгээд нь энэ тухайгаа энэ дүрмийн 77.13 заалтын дагуу ИНЕГ-ын даргад мэдэгдэнэ.</p>	<p>- Amend.2-өөр өөрчлөгдсөн (2006)</p> <p>-Шаардлагыг нарийвчилж тусгасан</p>
<p>77.13 Мэдэгдэлд тавих шаардлага (a) Энэ зүйлийн (b) болон (c)-г харгалзан, 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь САА 24077/01 маягтыг бөглөж, дараах хугацаанд Даргад хүргүүлэх үүрэгтэй: (1) 77.5-ын дагуу барилга байгууламж барих, эсхүл өөрчлөхөөр санал болгосон өдрөөс 90 хоногийн өмнө; эсхүл (2) 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу ашиглахаар санал болгосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө. (b) Байгууламжийг яаралтай барих, эсхүл өөрчлөх, эсхүл байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг шаардсан, нийтийн зайлшгүй үйлчилгээ, нийтийн эрүүл мэнд, эсхүл нийтийн аюулгүй байдалтай холбоотой онцгой нөхцөл бий болсон тохиолдолд: (1) энэ зүйлийн (a)-д заасан мэдэгдлийн шаардлага хамаарахгүй; (2) тухайн барилга байгууламжийг барих, өөрчлөх, эсхүл ашиглахыг хариуцсан этгээд нь тухайн барилга байгууламжийг барьж, өөрчилж, эсхүл ашигласнаас хойш ажлын 5 хоногийн дотор САА 24077/01 маягтыг бөглөж, Даргад хүргүүлэх үүрэгтэй.</p>	<p>77.13. Өргөдөл гаргах (a) Өргөдөл гаргах этгээд нь энэ зүйлийн (б), (в)-д зааснаас бусад тохиолдолд ИНЕГ-077/01 маягтыг бөглөж барилга, байгууламжийг барих болон өөрчлөлт оруулахаар төлөвлөж байгаа өдрөөс 90 хоногийн өмнө ИНЕГ-ын даргад хүргүүлнэ. (б) Нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын үүднээс байгууламж барих, өөрчлөлт оруулах, эсвэл гэрэл, лазер, галт зэвсэг буюу тэсэрч дэлбэрэх зүйл ашиглах тохиолдолд уг ажлыг хариуцаж байгаа этгээд ИНЕГ-077/01 маягтыг бөглөж тухайн ажил эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад хүргүүлнэ.</p>	<p>-Amend.2-өөр нэмэлт өөрчлөлт орсон</p> <p>-“Маягтыг 7-оос доошгүй хоногийн өмнө бөглөх” гэснийг “5 хоногийн дотор” гэж өөрчлөгдсөн. - “үйл ажиллагаа эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө” гэснийг “5 хоногт өгсөн байх” гэж өөрчлөгдсөн</p>

<p>(с) Холбогдох НХУ-ний нэгж хяналт тавьж байгаа үед, ИНД-71-ийн дагуу тогтоосон хяналттай зоонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар санал болгож байгаа этгээдийг:</p> <p>(1) энэ зүйлийн (а)-ийн дагуу мэдэгдэл хүргүүлэхийг шаардахгүй;</p> <p>(2) тухайн агаарын зайг хариуцсан НХУ-ын нэгжээс ашиглалт эхлэхээс өмнө ажлын 5 хоногт өгсөн байх ёстой урьдчилсан зөвшөөрөлгүйгээр, хяналттай зоонд гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахыг зөвшөөрөхгүй.</p>	<p>(в) ИНД-71-д заасан нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ явагдаж байгаа үед гэрэл, лазер, галт зэвсэг ,эсвэл тэсэрч дэлбэрэх зүйл ашиглахаар төлөвлөж байгаа этгээд нь ИНЕГ-077/01 маягтыг бөглөж тухайн үйл ажиллагаа эхлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад хүргүүлнэ.</p>	
<p>77.15 Нэмэлт мэдэгдэлд тавих шаардлага</p> <p>(а) Энэ дүрмийн 77.5 болон 77.7-гийн дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь, хэрэв Дарга шаардвал, барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглаж эхлэх (аль хамааралтайг) огноог Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>(б) Байгууламж барих, эсхүл өөрчлөх талаар 77.5-ын дагуу Даргад мэдэгдэх шаардлагатай этгээд нь, тухайн байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>(с) Тухайн байгууламж өөрийн хамгийн дээд өндөрт хүрсэн үед, энэ зүйлийн (б)-д шаардсан мэдэгдэл нь, бүртгэлтэй геодезийн ажилтны гаргасан, тухайн байгууламжийн өндөр болон байршлын тодорхойлолт болон 77.21(d)-гийн дагуу Даргын тогтоосон аливаа тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн шаардлагын нийцлийн баталгааг агуулсан байх ёстой.</p> <p>(д) Энэ дүрмийн 77.5-ын дагуу мэдэгдэл гаргах байгууламжийг барих, эсхүл өөрчлөх төслийг зогсоосон этгээд нь тухайн төслийг зогсоосноос хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>(е) Байгууламжийг буулгаж байгаа, эсхүл нураасан байгууламжид хариуцлага хүлээсэн этгээд нь, хэрэв тухайн байгууламж нь 77.5-ын дагуу мэдэгдлийн шалгуурыг хангасан бол, тухайн байгууламжийг буулгасан, эсхүл нурааснаас хойш ажлын 5 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.</p>	<p>77.15. Өргөдөлд тавигдах шаардлагууд</p> <p>(а) Энэ дүрмийн 77.5 ба 77.7-ын дагуу, эсхүл ИНЕГ-ын шаардсанаар өргөдөл гаргах этгээд нь байгууламж барьж эхлэх, өөрчлөлт оруулах, эсвэл ашиглалтанд оруулах хугацааны талаар ИНЕГ-077/01 маягтад тодорхой дурдсан байна.</p> <p>(б) Энэ дүрмийн 77.5-ын дагуу гаргаж буй өргөдлийг ИНЕГ-т дор дурдсан хугацаанд ирүүлнэ:</p> <p>1/ барьж байгаа барилга, байгууламж болон оруулж байгаа өөрчлөлт нь тухайн талбайн газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метр хүрэхээс 5 өдрийн өмнө;</p> <p>2/ барьж байгаа байгууламж болон оруулж байгаа өөрчлөлт нь хамгийн өндөр цэгтээ хүрэхээс 5 өдрийн өмнө.</p> <p>(в) Энэ зүйлийн (б)-д заасан өргөдөлд ИНЕГ-ын байцаагчаас тухайн байгууламжийн өндөр, байрлал, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг нь энэ дүрмийн шаардлагад нийцэж байгаа эсэх талаар гаргасан тодорхойлолтыг хавсаргасан байна.</p> <p>(г) Энэ дүрэмд хамаарах байгууламж барих болон өөрчлөлт оруулж байгаа этгээд нь энэ ажлаа бүрмөсөн зогсоосон бол энэ тухайгаа уг ажлаа зогсоосноос хойш 5 хоногийн дотор ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ.</p> <p>(д) Энэ дүрэмд хамаарах байгууламжийг буулгах, эсхүл тухайн байгууламж гадны нөлөөгөөр өөрөө нурсан бол энэ тухай 5 хоногийн дотор ИНЕГ-т бичгээр мэдэгдэнэ.</p>	<p>-Amend.2-өөр нэмэлт өөрчлөлт орсон</p>
<p>77.17 Нисэхийн судалгаа</p> <p>(а) Дарга 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-ийн дагуу мэдэгдэл</p>	<p>77.17. Судалгаа хийх</p> <p>(а) ИНЕГ-ын дарга нь энэ дүрмийн 77.5 -77.11 заалтуудын дагуу</p>	

<p>хүлээн авч, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн тохиолдолд, нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэх эсэхийг тогтоох зорилгоор нисэхийн судалгаа <u>хийнэ</u>.</p> <p>(b) <u>Дарга</u> нисэхийн судалгааг хийхдээ, өөрийн хамааралтай гэж үзсэн этгээд, үйлдвэрлэлийн төлөөлөл, төлөөллийн бүлэг болон байгууллагатай <u>зөвлөлдөнө</u>.</p>	<p>өргөдлийг хүлээн авч эдгээр барилга, байгууламж, ажил үйлчилгээ нь нам өндрийн нислэгт аюул учруулах эсэх талаар судалгаа <u>хийлгэнэ</u>.</p> <p>(б) <u>ИНЕГ</u> нь шаардлагатай гэж үзсэн мэргэжилтнүүд, үйлдвэрлэлийн төлөөлөгчид болон холбогдох байгууллагыг <u>судалгааны ажилд татан оролцуулж</u> болно.</p>	<p>-Орчуулга найруулга зассан</p>
<p>77.19 <u>Аюулыг тогтоох стандарт</u></p> <p>(a) Хэрэв байгууламж нь тухайн байрлалын AGL 120 м, эсхүл түүнээс өндөр бол, Дарга тухайн байгууламжийг <u>нислэг үйлдэх агаарын зайд</u> аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(b) Хэрэв байгууламж нь тухайн аэродромд хамааралтай саадыг хязгаарлах гадаргууг дайрч 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх, эсхүл үүсгэж болох бол, Дарга тухайн байгууламжийн ашиглалт нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(c) Хэрэв байгууламж нь AGL <u>120</u> м-ээс дээш өндөрт, 4.3 м/с-ээс дээш хурдтай агаарын урсгал үүсгэх, эсхүл үүсгэж болох бол, Дарга тухайн байгууламжийн ашиглалт нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</p> <p>(d) Хэрэв тухайн гэрлийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол, <u>Дарга</u> тухайн гэрлийн хэрэглээ <u>нислэг үйлдэх агаарын зайд</u> аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</p> <p><u>(e) Хэрэв лазерын түсгал нь нислэг үйлдэх агаарын зайд хэрэглэгдэх S/AS 2211 стандартад заасан зөвшөөрөгдөх максимум хэмжээнээс их бол Дарга тухайн саналын тодорхой нөхцөлд үндэслэн тухайн лазерын хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоож болно.</u></p> <p><u>(f) Хэрэв зэвсгийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол Дарга тухайн зэвсгийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</u></p> <p><u>(g) Хэрэв пиротехникийн хэрэглээ нь нислэг үйлдэх агаарын зайд аюул үүсгэхийг дүн шинжилгээгээр илрүүлсэн бол, Дарга тухайн пиротехникийн хэрэглээ нислэг үйлдэх агаарын зайд аюултай болохыг тогтоох үүрэгтэй.</u></p> <p>(h) <u>Дарга</u> саналын тодорхой нөхцөлд үндэслэн, дараах тохиолдолд тухайн байгууламж нь нислэг үйлдэх <u>агаарын зайд аюултай болохыг тогтоож</u> болно, хэрэв:</p>	<p>77.19. <u>Нам өндрийн нислэгт саад учруулж болзошгүй барилга байгууламж, ажил үйлчилгээнд тавигдах шаардлагууд</u></p> <p>(a) Энэ дүрмээр, дараах барилга байгууламжуудыг <u>нам өндрийн нислэгт</u> аюул учруулна гэж үзнэ:</p> <p>1/ тухайн талбайн газрын гадаргуугийн түвшнээс дээш 120 метр буюу түүнээс дээш өндөртэй, эсхүл;</p> <p>2/ тухайн талбайн газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метр өндөр, агаарын хөлгийн ил харааны нислэгт шилжих шугам ба бүсээс 1 км-ын дотор байгаа, эсхүл;</p> <p>3/ байгууламж нь аэродромын саадын хязгаарлагдах гадаргуугийн дагуу 4.3 м/сек-ээс дээш салхины нөөлгө, хуйлрал үүсгэх магадлалтай бол;</p> <p>4/ байгууламж нь газрын гадаргуугийн түвшнээс <u>60</u> метрээс дээш зайд 4.3 м/сек-ээс дээш салхины нөөлгө, хуйлрал үүсгэх магадлалтай бол.</p> <p>(б) <u>ИНЕГ</u> нь гэрэл, лазер, галт зэвсгийг ашиглах нь <u>нам өндрийн нислэгт</u> аюул учруулах эсэхийг судалгаа шинжилгээ хийсний үндсэн дээр тогтооно.</p> <p>(в) <u>ИНЕГ</u> нь дараах нөхцөлд тухайн барилга, байгууламжийг <u>нам</u></p>	<p>-NZ Part 77 Amend.2-өөр өөрчлөгдсөн (2006)</p> <p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>

(1) байгууламж нь ICAO Doc 8168-OPS/611-т заасан хэрэглэлийн нислэгийн журмын бүсэд байрладаг, стандарт нисэн ирэх нислэгийн зам, эхний дунд, төгсгөлийн, ил харааны болон ойртолтоос 2-т гарах сегментийн бүс, нисэн гарах бүс болон нисэн гарах стандарт хэрэглэлийн нислэгийн замыг багтаасан бөгөөд дараах нөлөө үзүүлэх бол:

(i) тухайн бүс, эсхүл сегментийн доторх байгууламжийн цэг болон тогтоосон хэрэглэлийн нислэгийн минимум түвшний хоорондын босоо зай нь хэрэглэлийн нислэгийн журамд шаардсан саадыг давах зайнаас бага байх; эсхүл

(ii) тухайн бүсээс нисэн гарахад хамаарах нэмэлт, эсхүл шинэ үүлний сүүрийн өндөр, эсхүл алсын барааны харагдцын хязгаарлалт, эсхүл нислэгийн журмын өөрчлөлтөд; эсхүл

(2) мөрдөж байгаа, эсхүл төлөвлөсөн минимум саадыг давах түвшнийг нэмэхийг шаардсан байгууламж нь Монгол улсын нислэгийн замын дагуух болон бүсийн нислэгийн зураг дээр дүгнэлт хийгдсэн нислэгийн зам багтсан боловч Монгол Улсын AIP-д хэвлэн нийтэлсэн зурагдсан нислэгийн зам ороогүй IFR нислэгийн замын дагуух саадыг давах бүсэд байрладаг бол; эсхүл

(3) байгууламж нь тухайн бүсийн модны нийтлэг өндрөөс 18 м-ээр илүү гарсан ба нам өндрийн агаараас гүйцэтгэх ажиллагааны бүсэд, эсхүл бусад нам өндрийн нислэгийн бүс, эсхүл ИНД-71-ийн дагуу тогтоосон нам өндрийн нислэгийн зоонд, эсхүл нам түвшний нислэгийн замд байрладаг бол; эсхүл

(4) байгууламж нь аэродромын саадыг хязгаарлах гадаргууг нэвтлэдэг бол.

өндрийн нислэгт аюул учруулж болзошгүй гэж үзнэ:

1/ байгууламж нь тухайн талбайн газрын гадаргуугийн түвшнээс дээш 60 метрийн өндөртэй хэвтээ хавтгайд байрлаж байгаа бол;

2/ байгууламж нь ICAO-гийн Doc 8168-OPS/611-д заасан хэрэглэлээр нислэг үйлдэх бүс, мөн ойртолтын бүс болон хөөрөлтийн бүсийн хүрээнд байрлаж байгаа бол;

3/ байгууламж нь хэрэглэлийн нислэгийн чиглэлийн саадаас зайлах бүсийн дотор байрлаж байгаа бол;

4/ байгууламж нь ой модны оройгоос 18 м-ээс дээш өндөрт, эсхүл аэродромын радионавигацийн болон радиолокаторын антенд үйлчилгээ хийдэг бүсэд байрлаж байгаа бол;

5/ байгууламж нь аэродромд ойрхон ба саадын хязгаарлагдах гадаргуугаас өндөрт байрлаж байгаа бол.

77.21 Шийдвэр гаргах

(a) Дарга, 77.13(a)-ийн дагуу байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах аливаа мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 28 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал болгосон барилга байгууламжийг барих, өөрчлөх, эсхүл ашиглах нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болох эсэхийг тогтоох шийдвэр гаргаж мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Дарга үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.

(b) Дарга, 77.13(a)-ийн дагуу гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах аливаа мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 10

77.21. Өргөдлийг шийдвэрлэх

(a) ИНЕГ-ын дарга нь барилга, байгууламж барих, өөрчлөлт оруулах талаар энэ дүрмийн 77.13 (a)-ийн дагуу гаргасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэж хүсэлт гаргагч болон холбогдох этгээдүүдэд мэдэгдэнэ.

(б) ИНЕГ-ын дарга нь энэ дүрмийн 77.13 (б)-гийн дагуу гаргасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор

- “21 хоног” гэснийг “28 хоног” гэж өөрчлөгдсөн

- “3 хоног” гэснийг “10 хоног” гэж өөрчлөгдсөн

<p>хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал нь нислэг үйлдэх агаарын зайд аюултай болох эсэхийг тогтоох шийдвэр гаргаж мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Дарга үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.</p> <p>(c) Дарга, 77.13(c)-гийн дагуу мэдэгдэл хүлээн авснаас хойш ажлын 4 хоногийн дотор, хэрэв тухайн саналыг хэрэгжүүлсэн бол, санал болгосон гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах нь, нислэг үйлдэх агаарын зайд аюултай болох эсэхийг тогтоох шийдвэр гаргаж, мэдэгдэл гаргагч болон тухайн шийдвэрт хамаатай гэж Дарга үзсэн бусад этгээдэд мэдэгдэнэ.</p> <p>(d) Дарга, шийдвэрийг нисэхийн судалгаагаар илрүүлсэн дутагдалд үндэслэн гаргах бөгөөд:</p> <p>(1) дараах нөхцөл, эсхүл хязгаарлалтыг тогтоож болно:</p> <p>(i) Хавсралт В -д дүрсэлсэн тэмдэглэгээ, эсхүл гэрэлтүүлгийн бүтцэд;</p> <p>(ii) нислэг үйлдэх агаарын зайн аюулыг багасгасан болохыг бататгах;</p> <p>(iii) нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй гэж үзсэн шийдвэрт, хүндрэл үүсгэж болох асуудлыг багасгахад шаардлагатай гэж үзсэн, жишээ нь: барилга байгууламжийн түр төхөөрөмж ашиглах;</p> <p>(2) мэдэгдэлд тавих нэмэлт шаардлагыг тодорхойлж болно.</p>	<p>шийдвэр гаргаж холбогдох этгээдүүдэд мэдэгдэнэ.</p> <p>(в) ИНЕГ-ын дарга нь гэрэл, лазер, галт зэвсэг болон тэсэрч дэлбэрэх зүйл ашиглах талаар энэ дүрмийн 77.13 (в)-гийн дагуу гаргасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэж хүсэлт гаргагч болон холбогдох этгээдүүдэд мэдэгдэнэ.</p> <p>(г) ИНЕГ-ын дарга нь зөвшөөрсөн шийдвэр гаргасан бол зөвшөөрөлдөө дараах зүйлүүдийг тусгана:</p> <p>1/ саад болж болзошгүй барилга, байгууламж, ажил үйлчилгээний нөхцөл ба хязгаарлалтууд:</p> <p>1.1 Хавсралт Б-д үзүүлсэн өндөр цамхагийн тэмдэглэгээ буюу гэрэлтүүлэгт хамрагдахыг;</p> <p>1.2 нам өндрийн нислэгт учирч болох аюулыг хамгийн бага хэмжээнд байлгахыг;</p> <p>2/ нэмэлт шаардлагууд.</p>	<p>-“4 хоног”гэснийг ”10 хоног” гэж өөрчлөгдсөн</p>
<p>77.23 Нийцэл Даргад мэдэгдэл хүргүүлэх 77.5, 77.7, 77.9, эсхүл 77.11-т шаардсан этгээд нь 77.21(d)-гийн дагуу тогтоосон шаардлага, нөхцөл, эсхүл хязгаарлалтыг дагаж мөрдөнө.</p>	<p>77.23. Нөөц</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>
<p>77.25 Шийдвэрийн хүчинтэй өдөр болон хугацаа (a) Дараах санал болгосон ажлын талаарх шийдвэр нь: (1) Дарга 77.27(b)-гийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах үйл ажиллагаа нь 77.21(a)-ийн дагуу шийдвэр гарсан өдрөөс хойш 28 хоногийн дараа эцсийн байдлаар хүчинтэй болно; (2) Дарга 77.27(b)-гийн дагуу эргэн хянах хүсэлт хүлээн авснаас бусад тохиолдолд, 77.13(a)-ийн дагуу мэдэгдсэн гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах ажиллагаа нь, САА 24077/01 маягтаар Даргад хүргүүлсэн, ашиглахаар санал болгосон өдрөөс ажлын 5 хоногийн өмнө эцсийн байдлаар хүчинтэй болно. (b) 77.29-ийн дагуу эргэн хянасан, эсхүл сунгаснаас бусад</p>	<p>77.25. Нөөц</p>	<p>-Орхигдуулсан заалтыг нөхөж оруулсан</p>

тохиолдолд, нислэг үйлдэх агаарын зайд аюулгүй болох талаар энэ Дүрмийн дагуу гаргасан эцсийн шийдвэр нь:

(1) байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах үйл ажиллагааны хувьд, тухайн шийдвэр эцсийн байдлаар хүчинтэй болсноос хойш 18 сарын дараа, эсхүл санал болгосон барилга байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах ажиллагааг цуцалсан өдрийн аль түрүүлж болох хугацаанд хүчингүй болно;

(2) гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглах талаар САА 24077/01 маягтаар Даргад мэдэгдсэн ажиллагааг гүйцэтгэж дуусахад, эсхүл санал болгосон ажиллагааг цуцалсан өдрийн, аль түрүүлж болох хугацаанд хүчингүй болно.

(с) Аюултай гэж гарсан эцсийн шийдвэр нь :

(1) 77.25(а)(1), эсхүл 77.27(ф)(2)-ын дагуу, байгууламж барих, өөрчлөх, эсхүл ашиглах ажиллагааны хувьд хугацаагүй байх ба гэхдээ Дарга бичгээр хүчингүй болгож болно;

(2) 77.25(а)(2), эсхүл 77.27(ф)(2)-ын дагуу, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглалтын хувьд САА 24077/01 маягтад заасан хугацаанд ажиллагааг гүйцэтгэж дуусахад, эсхүл Дарга сунгаж зөвшөөрсөн өдрийн дараах өдөр хүчингүй болно.

77.27 Аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянах хүсэлт

(а) Байгууламж барих, эсхүл өөрчлөх, эсхүл байгууламж, гэрэл, лазер, зэвсэг, эсхүл пиротехник ашиглахаар санал болгож байгаа этгээд нь Даргын гаргасан аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх хүсэлтийг Даргад гаргаж болно.

(б) Аюултай гэж үзсэн шийдвэрийг эргэн хянаж үзэх тухай бичгээр гаргасан хүсэлт нь 77.25(а)-ийн дагуу шийдвэр эцсийн болохоос өмнө Даргад хүргэгдсэн байх ба:

(1) тухайн хүсэлт нь нисэхийн үндэслэлийн дэлгэрэнгүй мэдэгдлийг багтаасан байх;

(2) Дарга гаргасан шийдвэр, өөрчлөлт, эсхүл сунгалтаа эргэн хянаж үзэх болсон бодит үндэслэлийг багтаасан ба нисэхийн судалгааны явцад өмнө нь авч үзээгүй, эсхүл хэлэлцээгүй шинэ мэдээлэл, эсхүл баримтыг танилцуулсан байх;

(3) хэрэв эргэн хянах хүсэлт нь төсөөллийн, журмын тайлбарын, аюулын стандартыг хэрэглэсэн байдлын, эсхүл бодит байдлын таамаглалын алдаанд үндэслэсэн бол, тухайн хүсэлтийн үндэслэлийг тодорхойлж, тайлбарлах.

(с) Энэ зүйлийн (б)-гийн дагуу ирүүлсэн эргэн хянах хүсэлтийг Дарга шалгаж шийдвэрлэх хүртэл, шийдвэр эцсийн болохгүй.

(д) Энэ зүйлийн (б)-гийн дагуу ирүүлсэн хүсэлтийг Дарга шалгаж

77.27. Хүсэлт гаргах

(а) ИНЕГ-ын дарга татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд барилга байгууламж барих, өөрчлөлт оруулах, гэрэл, лазер байрлуулах, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх зүйл хэрэглэх үйл ажиллагаа явуулах этгээд нь гаргасан шийдвэрээ эргэж харахыг хүсэж ИНЕГ- т хүсэлт гаргаж болно.

(б) Хүсэлтийг бичгээр ирүүлэх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

1/ үнэн бодит шалтгаан дээр үндэслэсэн байх;

2/ ИНЕГ-ын шинжилгээ, судалгаа хийх явцад судлагдаагүй, тусгайлан авч хэлэлцээгүй мэдээллийг агуулсан байх;

3/ аюул учруулахыг тогтооход ашигласан журмын талаар тодорхой баримт түшиглэсэн байх.

(в) ИНЕГ-аас хүсэлтийг дахин авч хэлэлцэж шийдвэр гаргах хүртэл барилга байгууламж барих, өөрчлөх болон ажил үйлчилгээ явуулахыг хориглоно.

-Орчуулга найруулга засагдсан

- “ИНЕГ-ын дарга татгалзсан шийдвэр” гэснийг “Даргын гаргасан аюултай гэсэн шийдвэр” гэж өөрчлөгдсөн

-Орхигдуулсан

<p><u>үзээд, эргэн хянах эсэхийг шийдвэрлэнэ.</u> <u>(е) Хэрэв Дарга эргэн хянахыг зөвшөөрсөн бол:</u> <u>(1) судалгаа хийх болон эргэн хянах асуудлыг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ, хэрэв тухайн хүсэлтэд дурдсан асуудал, эсхүл шийдвэр зөрүүтэй бол;</u> <u>(2) 77.21(a), (b), эсхүл (c)-гийн аль хамааралтай заалтын дагуу шийдвэр гаргахдаа зарцуулсан хугацаанаас бага хугацаанд эргэн хянах ажиллагааг дуусгана.</u> <u>(f) Хэрэв Дарга эргэн хянах ажиллагааг татгалзахаар шийдвэрлэсэн бол:</u> <u>(1) тухайн шийдвэрийн талаарх үндэслэлийг хүсэлт гаргагчид мэдэгдэнэ;</u> <u>(2) эргэн хянах ажиллагааг татгалзсан, эсхүл 77.25(a)-д заасны дагуу аль сүүлд болох хугацаанд шийдвэр нь эцсийн болно.</u></p>	<p>(г) <u>ИНЕГ нь</u> хүсэлтийг хүлээж аваад <u>дахин судалгаа</u> хийх шаардлагагүй гэж үзвэл: 1/ хүсэлт гаргагчид шийдвэрийнхээ үндэслэлийг <u>тайлбарлана;</u> 2/ өмнө нь гаргасан шийдвэр хүчин төгөлдөр байгааг нотлоно.</p> <p><u>(д) Энэ дүрмийн дагуу ИНЕГ-аас зөвшөөрөл олгогдсон этгээд нь тухайн барилга байгууламжийн ажил эхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах, хойшлуулах хүсэлт гаргаж болно. ИНЕГ нь хүсэлтийг дараах байдлаар шийдвэрлэнэ:</u> <u>1/ хүсэлтийн үндэслэлийг нарийвчлан судлана;</u> <u>2/ барилга, байгууламж барих, өөрчлөх тохиолдолд 6 сараас дээшгүй, гэрэл, лазер, галт зэвсэг болон тэсэрч дэлбэрэх зүйлс ашиглах тохиолдолд 14 хоногоос дээшгүй хугацаагаар сунгаж болно.</u></p>	<p>заалтыг нөхөж оруулсан</p>
